

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Бизнес эрхлэлтийн индекс хариуцсан мэргэжилтэн, Болдоо Оюунтүлхүүр
2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;							
1	3.1.1. Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаж, бодлого зохицуулалтаар хангана.	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө" батлагдсан.	Монгол Улсын 2026 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж танилцуулгад тусгах. /1 танилцуулга /	"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тодорхойлсон "Бүсчилсэн хөгжлийн бодлого", "Хүний хөгжлийн бодлого", "Эдийн засгийн бодлого", "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого" гэсэн бодлогын 4 тэргүүлэх чиглэлийг үргэлжлүүлнэ. Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл нь "ХҮН ТӨВТЭЙ" хөгжлийн үзэл санаанд нийцсэн "ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ЦОГЦЛООХ"-ыг зорьж төсвийн зардлын реформ, төрийн албаны реформ, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформыг хэрэгжүүлэх бөгөөд тус реформууд нь ядуурлыг	3-р сар, 4-р сар, 9-р сар, 10-р сар	100%

					бууруулахад чиглэгдэнэ. 2026 онд нэн шаардлагатай салбарын реформ, тэргүүлэх ач холбогдолтой хөгжлийн 14 мега төслийг эрчимжүүлж, макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, бизнесийн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог багасгах замаар ядуурлыг бууруулж, эдийн засгийн эрх чөлөөний реформыг хэрэгжүүлнэ. Олон улсад зарлагддаг, нэр хүнд бүхий индексүүдийг судалснаар тухайн орны дэлхийн улс орнуудын дунд хэрхэн эрэмбэлэгдэж, ямар үзүүлэлтээр сул байгаа, ямар үзүүлэлтээр давуу байгааг харах боломжийг олгодог. Ингэснээр ямар үзүүлэлт, цаашлаад салбар, чиглэлийг илүү анхаарч сайжруулах шаардлагатайг тодорхойлоход хэрэгцээтэй мэдээллийг олж авч болдог. Энэ хүрээнд Дэлхийн өв сангаас гаргадаг "Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс", Дэлхийн банкны "Бизнес эрхлэх таатай орчны индекс", Транспаренси интернэйшнл байгууллагын "Авлигын төсөөллийн индекс", IMD-ийн "Дэлхийн өрсөлдөх чадварын индекс", Бертельсман сангийн "Шилжилтийн индекс", Дэлхийн банкнаас гаргадаг "Засаглалын үзүүлэлтүүд" зэргийг судалж эдийн засгийн тэргүүлэх чиглэл тодорхойлох суурь судалгааг хийн бизнесийн орчин, засаглал, хөдөлмөрийн зах зээлийг сайжруулах хүрээнд тэргүүлэх		
--	--	--	--	--	--	--	--

					чиглэлд санал өгсөн болно. Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан болно. Хавсралт: 1 файл		
1.2. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогыг тодорхойлох, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл гаргах;							
2	Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулна.	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох	-	Эдийн засгийн 2026 оны тооцоо төсөөлөл, танилцуулга бэлтгэх /1 танилцуулга/	Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө боловсруулах хүрээнд Макро эдийн засгийн нөхцөл байдал, салбаруудын өнөөгийн нөхцөл байдал, 2024 оны урьдчилсан гүйцэтгэл, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, чиг хандлага, макро эдийн засгийн 2026 оны төсөөлөл, болзошгүй эрсдэлийн тойм зэрэг тооцоо танилцуулгыг бэлтгэсэн. Улсын хөгжлийн төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаан болон байнгын хороогоор танилцуулж, 2025 оны 4 сарын 29-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Хавсралт: 1 файл	4-р сар, 5-р сар	100%
3	Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macroeconomic diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэнэ	Танилцуулгын тоо	Өмнөх онуудад эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, улирал бүр тайлан бэлтгэсэн.	2025 оны I, II улиралд дүн шинжилгээ хийж танилцуулга бэлтгэсэн байна. /2 танилцуулга/	Макро эдийн засгийн 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 1 дүгээр улирлын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, танилцуулга боловсруулахад "Олон улсад зарлагдсан индексүүд" болон "Хөдөлмөр, аж ахуйн нэгж" бүлгүүдийг бичсэн. Үүний хүрээнд, олон улсад шинэчлэгдэн зарлагдсан Авлигын төсөөллийн	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	100%

					индекс, Хуулийн засаглалын индекс, Бизнес эрхлэх таатай орчны индекс, Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс, Эдийн засгийн цогц байдлын индекс, Хүний хөгжлийн индексүүдийн Монгол Улсын үнэлгээ болон олон улсын чиг хандлагад шинжилгээ хийж тайланд тусгав. Түүнчлэн ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлт, цалингийн үзүүлэлтүүд, аж ахуйн нэгжийн тоо, аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын тоон мэдээлэлд шинжилгээ хийж тайланд тусгасан болно. Хавсралт: 1 файл		
1.3. Эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эдийн засагт тулгарч болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлох;							
4	Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр танилцуулга бэлтгэн, удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана.	Танилцуулгын тоо	2024 онд сар бүр танилцуулга бэлтгэсэн.	2024 оны 1-6 сард танилцуулга бэлтгэсэн байна./6 танилцуулга/	Тус газраас макро эдийн засгийн сарын мэдээний танилцуулгыг боловсруулан бэлтгэж байна. Энэ хүрээнд олон нийтэд нээлттэй байдаг тоо, мэдээллийг ашиглан тооцоо, шинжилгээ хийж олон нийтэд хүргэх хувилбарыг яамны албан ёсны цахим хуудасны https://med.gov.mn/monthlyreport холбоост болон Macro channel нэртэй вайбэр суваг үүсгэн англи болон монгол хэлээр байршуулж ажиллаж байна. Мөн дотоодын байгууллагуудаас тоо, мэдээлэл нэмэлтээр авч яамны удирдлагуудад зориулсан дэлгэрэнгүй хувилбарыг А5 хэмжээтэй товхимол болгон хэвлэж гаргадаг бөгөөд мөн адил англи, монгол хувилбараар бэлтгэж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					Макро эдийн засгийн сарын мэдээний дээрх хоёр хувилбарт тус хэлтсээс хариуцан ажилладаг хөдөлмөрийн зах зээл, бизнесийн орчны тоо, мэдээлэлд суурилсан тооцоо, шинжилгээг танилцуулгад сар бүр оруулж ажиллаж байна. Түүнчлэн тус хэлтэс сарын мэдээний танилцуулгыг яамны цахим хуудас болон Вайбэр сувагт байршуулж олон нийтэд түгээх ажлыг гүйцэтгэж байна. Хавсралт: 1 файл		
1.4. Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах бодлогын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор судалгааг хөгжүүлэхэд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;							
5	Дата баазууд боловсруулж эдийн засгийн судалгаанд ашиглана. (Гаалийн дата, И-баримт гэх мэт)	Тайланд ашигласан тоо	-	Улирлын тайланд ашигласан байна. /1 удаа/	НӨАТ-ын дата баазад суурилж аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын сар, улирлын давтамжтай дата, мэдээллээр мэдээллийн сан үүсгээд байна. Гааль, И-баримтын датаг сар бүр тогтмол авч аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого, НӨАТ-ын шивсэн баримтын тоонд тооцоо, судалгаа хийж макро эдийн засгийн улирлын танилцуулгад оруулж, удирдлагыг холбогдох мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна. Мөн өрхийн худалдан авах чадварын индекс боловсруулах зорилгоор Санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран 4 дэлгүүрийн 6 барааны худалдан авалтын дүнг И-баримтын тоон мэдээлэлд үндэслэн тодорхойлж, туршилт тооцоог боловсруулаад	3-р сар, 9-р сар, 12-р сар	100%

					байна.		
1.5. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлэх;							
6	Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн болон төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.	Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл	Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2026-2028 оны тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулсан байна/ 1 танилцуулга/	Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах хүрээнд тус хэлтсээс хариуцдаг хөдөлмөр эрхлэлт, бизнес регистрийн үзүүлэлтээр тооцоо, төсөөлөл хийж танилцуулгад тусган ажилласан. Мөн танилцуулгын хамт бэлтгэсэн Эрсдэлийн тайланд Хөдөлмөрийн эрсдэлүүдийн талаар судлан оруулсан болно. Түүнчлэн Засгийн газрын хуралдаан, Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхэд удирдлагуудыг мэдээллээр хангаж хэлтсийн хариуцсан асуудлаар шипи боловсруулж, холбогдох бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Тус хууль 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан болно.	3-р сар, 4-р сар, 5-р сар	100%
1.6. Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн олон улс дахь эрэмбийг ахиулах зорилгоор судалгаа, шинжилгээнд үндэслэн бодлогын нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах.							
7	Улсын эдийн засгийн өрсөлдөх чадварыг Өв уламжлалын сангаас гаргадаг Эдийн засгийн эрх чөлөөний байдлын индекст тулгуурлан судалж, сайжруулах арга хэмжээний төсөл бэлтгэнэ.	Арга хэмжээний төслийн тоо	-	Арга хэмжээний төсөл боловсруулсан байна. /1 арга хэмжээний төсөл/	Өв уламжлалын сангийн "Эдийн засгийн эрх чөлөөний байдлын индекс", Дэлхийн банкны "Бизнес эрхлэх таатай орчны индекс", IMD-ийн "Дэлхийн өрсөлдөх чадварын индекс", МҮХАҮТ-ийн "Бизнесийн орчны өрөнхий үнэлгээ"-нд суурилж бизнес эрхлэх орчинд тулгамдаж буй асуудлын талаар судлав. Судалгааны үр дүнг Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%-

					өдрийн хуралдаанд танилцуулснаар бизнес эхлүүлэхэд гардаг хүндрэл, шат дамжлагыг бууруулах, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог багасгах чиглэлээр 7 дугаар тэмдэглэл гарав. Энэ хүрээнд хуулийн этгээд байгуулах хугацааг 3 хоногт багтаах, байгаль орчны үнэлгээ шаардлагатай бизнесийн төрлийг цөөлөх, цахилгаан эрчим хүчинд холбогдох хугацааг 40 хоногт багтаах, тусгай зөвшөөрлийн үйлчилгээг цахимжуулж, төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбох, төрөөс зах зээлд нөлөөлөх арга хэмжээ хэрэгжүүлэхийн өмнө үе шаттай зогсоох стратеги (exit strategy) боловсруулах, хүнс, хөдөө аж ахуйн салбарын татаас, дэмжлэгийн үр ашгийг үнэлж, үе шаттайгаар бууруулах, ҮЦТХТ-өөс өмчлөх эрхийн тухайлсан бүртгэл, хадгаламжийн үйл ажиллагааг брокер, кастодианд шилжүүлэх боломжийг судлах зэрэг үүрэг, даалгавар өгөгдөөд байна. Хавсралт: 1 файл		
8	Транспаренси Интернэшнлээс гаргадаг Авлигын төсөөллийн үзүүлэлтийн талаар бэлтгэсэн танилцуулгыг 2025 онд шинээр	Танилцуулгын тоо	-	Танилцуулга боловсруулсан байна./1 танилцуулга/	Транспаренси Интернэшнл байгууллагаас гаргадаг Авлигын төсөөллийн индексийн үзүүлэлтүүдийн дата мэдээллийг 8 эх сурвалжийн судалгаа, тайлангаас нэгтгэн цуглуулж, эх сурвалж тус бүрээр үнэлгээ, үнэлгээний өөрчлөлтөд дүн	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

	зарлагдахтай. холбогдуулан шинэчилж удирдлагад танилцуулна				шинжилгээ хийж дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэн, удирдлагуудад танилцуулж ажилласан. Хавсралт: 1 файл		
9	ФАТФ-ын саарал жагсаалтад орох эрсдэлийн талаар судалж удирдлагад танилцуулна.	Танилцуулгын тоо	-	Танилцуулга боловсруулсан байна. /1 танилцуулга/	ФАТФ-ын 40 зөвлөмж болон 11 шууд хэрэгжилтийн шалгуурын хүрээнд Монгол Улсын нөхцөл байдлыг үнэлэх судалгааг шат дараатайгаар гүйцэтгэж байна. 2017 онд хийсэн сүүлийн дэлгэрэнгүй үнэлгээнээс хойш шинэ үнэлгээ хийгдээгүй тул зөвлөмж тус бүрийн холбогдох хууль эрх зүй, бодлого зохицуулалт, институцын зохион байгуулалт зэрэг мэдээллийг нээлттэй эх сурвалжаас нэг бүрчлэн судалж, хэрэгжилтийн түвшинг 2017 оны үнэлгээтэй харьцуулан шинэчлэн үнэлэхээр ажиллаж байна. Судалгааны үр дүнг нэгтгэн, ФАТФ-ын саарал жагсаалтад орох эрсдэлийг урьдчилан тодорхойлох, холбогдох бодлогын анхаарах чиглэлүүдийг тодорхойлоход чиглэсэн дүн шинжилгээг боловсруулж байна. Хавсралт: 1 файл	1-р сар, 2- р сар, 3-р сар, 4-р сар	100%
10	Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн тав дахь шатны хэлэлцээг	Хэрэгжилтийн явц /хувь/	-	Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/	Монгол Улс, БНСУ хооронд байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн тав дахь шатны хэлэлцээний бэлтгэл ажлын хүрээнд Үйлчилгээний худалдааны бүлгийн хувьд Солонгосын талтай хоёр удаа санал солилцож, холбогдох яамдтай уулзалт хийв.	1-р сар, 2- р сар, 3-р сар, 4-р сар	100%

	Үйлчилгээний худалдааны бүлгийн хувьд хийх, бэлтгэл ажлыг хангахад хувь нэмэр оруулна.				2025 оны 3 дугаар сарын 10-11-нд бизнес эрхлэгчдийн оролцоог хангах нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, олон нийтийн санал бодлыг нэгтгэв. Тус хэлэлцээрийн явц 4 дүгээр сараас удирдлагын шийдвэрээр тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон байгаа болно.		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Газрын чиг үүрэгт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдаж, ур чадвараа дээшлүүлсэн байх	Газрын чиг үүрэгт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдаж, ур чадвараа дээшлүүлсэн байх	-	Газрын чиг үүрэгт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдаж, ур чадвараа дээшлүүлсэн байх	Германы хамтын ажиллагааны байгууллагаас зохион байгуулсан "Байгууллагын менежмент, багаар ажиллах ур чадвар, өөрийн давуу болон сул тал, багийн гишүүдтэй хамтран ажиллах, илтгэлцлийн талаар"	6-р сар, 12-р сар	100%

					сургалтад хамрагдсан.		
2	Газрын чиг үүрэгт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах	Газрын чиг үүрэгт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах	-	Газрын чиг үүрэгт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд ажлын цагийг үр бүтээлтэй ашигласан байна.	Газрын чиг үүрэгт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд ажлын цагийг үр бүтээлтэй ашигласан	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр

/...../

Огноо: 2025.06.25

ТУ32861 6306236 9022010236

ТАЙЛАН ГАРГАСАН:

Бизнес эрхлэлтийн индекс хариуцсан мэргэжилтэн, Болдоо Оюунтүлхүүр

/...../

Огноо: 2025.06.25